

**“БАЯЛАГ СҮМБЭР ХК”-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 5-р сарын 15

№ 19/5-2

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61.1.5, 67.1, 71.3, 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14 ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”, Баялаг сүмбэр ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх) –ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 2019 оны 5-р сарын 15-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн ээлжит бус Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 7 сарын 1 ны өдрийн Даваа гарагт 10:00 цагт “Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Маңдал хотхон, 42-11 тоот” хаягт зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 6 сарын 6-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд хурлын материалыг 2019 оны 5 сарын 23 ны өдөр үнэт цаасны компанид цахим шуудан болон бичгээр илгээх ба хувьцаа эзэмшигчид компанийн байранд дээрх өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцаж болохыг түгээсүгэй.
4. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2019 оны 6 сарын 28 ны өдрөөр тогтоож, компанийн байранд авахаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2019 оны 5 сарын 20 ны өдөр болон, давтан 15 хоногийн дараа буюу 6 сарын 3 ны өдрөөр тогтоох, Зарын агуулгыг “хавсралт 3”-аар тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комиссын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б. Отгонбаатарыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б. Отгонбаатарыг томилсугай.
8. Хурлын тооллогын комиссоор П.Очирхуягийг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг “хавсралт №1”-ээр баталсугай.

**“БАЯЛАГ СҮМБЭР ХК”-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг “хавсралт №2”-өөр баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэл зарын загварыг “хавсралт №3”-оор баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал авах хуудсыг “хавсралт №4”-аар баталсугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Yeh Montgomer / YEH MONTGOMER /